

**Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгчийн  
урилгаар  
БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн Ерөнхийлөгч,  
Вьетнамын Коммунист Намын Төв Хорооны гишүүн,  
доктор, профессор Нгуен Суан Тханг тэргүүтэй  
төлөөлөгчид айлчиллаа**

Б.Цэнгэллхам<sup>1</sup>

Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгчийн урилгаар БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн Ерөнхийлөгч, Вьетнамын Коммунист Намын Төв Хорооны гишүүн, доктор, профессор Нгуен Суан Тханг тэргүүтэй төлөөлөгчид 2012 оны 5 сарын 30-аас 2012 оны 6 сарын 2-ны хооронд манай оронд айлчиллаа. Айлчлалын бүрэлдэхүүнд БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн дэд ерөнхийлөгч, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга болон Европ судлалын хүрээлэн, Тогтвортой хөгжлийн төв хүрээлэнгийн захирлууд, Хятад судлалын хүрээлэн, Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дэд захирлууд бүхий 8 хүн багтсан нь Вьетнамын тал өндөр ач холбогдол өгсний тод илрэл боллоо. Энэхүү айлчлалын гол зорилго нь манай улсын ШУА, БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн хооронд шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах гэрээ байгуулж, гарын үсэг зурах явдал байлаа.

Зочдыг манай улсын ШУА-ийн удирдлагууд, УИХ-ын Нийгмийн бодлого, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга А.Тлейхан хүлээн авч уулзлаа. Мөн манай нийгмийн шинжлэх ухааны салбарын хэд хэдэн хүрээлэн, тухайлбал Олон улс судлалын хүрээлэн, Үндэсний хөгжлийн хүрээлэн, Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн үйл ажиллагаатай танилцан, үндэсний шилдэг үйлдвэрүүдийн төлөөлөл болох Говь, АПУ компанийн үйлдвэрүүдийг үзэж сонирхлоо.

Айлчлалын эхний өдөр Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгч Б.Энхтүвшин зочдыг өөрийн байгууллага дээрээ хүндэтгэн хүлээн авч уулзав. Уулзалтанд ШУА-ийн дэд ерөнхийлөгч профессор Т.Дорж, гадаад харилцааны хэлтсийн дарга, элчин сайд Л. Даваагив, ОУСХ-ийн захирал, профессор Л. Хайсандай, ҮХХ-ийн захирал, бага чуулганы гишүүн доктор, профессор Б. Цогоо, ОУСХ-ийн эрдэмтэн

нарийн бичгийн дарга Д. Шүрхүү, ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Б. Цэнгэлхам, профессор Ц.Дашцэвэл нар байлцлаа.

ШУА-ийн Ерөнхийлөгч Б.Энхтүвшин зочдыг хүлээн авч, өөрийн орны болон байгууллагынхаа талаар танилцуулж хэлэхдээ:

“Та бүхнийг өөрийн байгууллага дээрээ хүлээн авч уулзаж байгаадаа баяртай байна. БНСВУ-аас манай улсад суугаа ЭСЯ, ноён элчин сайд Монгол Вьетнамын харилцааг бэхжүүлэхэд их зүйл хийж байгааг энд тэмдэглэн хэлмээр байна.

Хоёр орны харилцаанд боловсрол, соёл, шинжлэх ухааны харилцаа онцгой ач холбогдолтой гэж би ойлгодог. Тийм учраас та бүхний энэ айлчлал манай хоёр орны шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх эхлэлийг тавихад их чухал хувь нэмэр үзүүлнэ гэж найдаж байна. Богино хугацаанд манай зарим хүрээлэнгүүдээр орж, Монголын шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх боломж бий болгох байх гэж бодож байна. Монгол оронд тавтай айлчлахыг хүсье.

Монгол орон, Монголчууд их түүхтэй орон. Та бүхэн сайн мэдэж байгаа. Гадны судлаачид бичсэн байдаг. Монголчууд түүхийн тавцанд нэг гарч ирээд, нэг алга болоод, дахиад гараад ирдэг, түүхийн тавцангаас арчигддаггүй ийм цөөнх боловч агуу үндэстэн гэж.

Ноён элчин сайд мэдэж байгаа. Өнгөрсөн жил биднийг МУ-ын хувьд түүхэн жил байсан. Хүннү гүрэн, Монголын анхны төр байгуулагдсаны 2200 жилийг ЮНЕСКО-гийн хүрээнд өргөн тэмдэглэлээ. Монголчуудын төрт ёсны уламжлал 2200 гаруй жилийн түүхтэй. Таны айлчилж байгаа энэ жил гэхэд Их Монгол улсыг үндэслэгч Чингис хааны мэндэлсний 850 жилийг тэмдэглэнэ. Таны айлчилж байгаа энэ үе бол дэлхий нийт, дэлхийн том компаниуд, уул уурхайн компаниуд, бизнесменүүдийн хараа Монголд чиглэсэн ийм үед та бүхэн айлчилж байна. 1,500,000 хавтгай дөрвөлжин нутаг дээр газрын хөрсөнд байгаа байгалийн баялгийн үүцээ нээж байна.

Манай ШУА үүссэн цагаасаа Монголынхоо геологийн тогтоц, геологийн судалгаа хийж ирсэн. Одоогийн энэ уурхайнууд нь нутаг дэвсгэрийн 40 хувьд судалгаа хийгдсэний үр дүнд гарч байгаа

юм. Гадаадын хөрөнгө оруулалтыг татаж байгаа үзүүлэлтээрээ, эдийн засгийн өсөлтөөрөө дэлхийн эхний 10-т орж байгаа улс бол Монгол улс. Энэ 2011 оны байдлаар эдийн засгийн өсөлт 17% нэмэгдсэн. Ойрын 3 жилдээ энэ үзүүлэлт буурахгүй нь тодорхой. Зэс, нүүрс, алт, уран олон төрлийн нөөцөөрөө эхний 5-д орж байна. Монгол улс 2,800,000 хүнтэй.

Би сая шавхагддаг баялгаас товчхон хэллээ. Манай улс шавхагддаггүй их баялагтай орон. Тэр бол таван толгой мал сүрэг. Нэг хүнд 11 толгой бод мал ногдож байна. Энэ их эдийн засгийн өсөлт хөгжлөө ард түмнийхээ амьдралд наалттай болгох бодлого бол Монголын засгийн газар, төрийн бодлогын үндэс байх ёстой гэж манай эрдэмтэд үздэг. Одоохондоо ард түмэн их баялгийн үр шимийг сайн хүртэж чадаагүй байна. Нэг хүнд ногдох ДНБ 2200 ам.доллар гаруй. Уул уурхайн эрчимтэй хөгжил бол нэг талаасаа эдийн засгийн өсөлтөө ард түмэндээ хүргэх, нөгөө талаасаа байгаль орчноо хамгаалах том асуудал. Хөгжлийн тогтвортой, ирээдүйд чиглэсэн бодлого зайлшгүй чухал гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл технологижсон, мэдээлэлжсэн, мэдлэгжсэн ногоон эдийн засаг бий болгох хэрэгтэй гэж үздэг. Байгаль орчны доройтлыг даван туулах, газрын хөрсийг хамгаалах нь манай эрдэмтдийн анхаарлын төвд байгаа чухал асуудал. Өнөөдөр Монгол орон экспортонд үндсэндээ түүхий бүтээгдэхүүн гаргаж байна. Аж үйлдвэрийн бүтэц их өрөөсгөл байна. Үүнийг өөрчлөх нь чухал гэж эрдэмтэд үздэг. 2005 оноос эрдэмтэд “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” боловсруулж Засгийн газартаа өргөн барьсан. Үүнийг удахгүй хэлэлцэх байх. Монгол улс инновацийн индекс үзүүлэлтээрээ доогуур буюу дэлхийн 150 орноос 102-т явж байна. Би танай орныг их урдуур байгаа байх гэж бодож байна. Экспортод өндөр технологийн бүтээгдэхүүн гуравхан хувь байна. Ийм учраас бодлогыг оновтой болгохын тулд эрдэмтдийн санаачлагаар 2007 онд “Монгол улсын хөгжлийн цогц бодлого” гэж бодлогын баримт бичиг гаргасан. УИХ-аар батлагдсан. Манай 300 гаруй эрдэмтэд оролцсон. Энэ баримт бичгийг боловсруулахад профессор Т.Доржийн ахалсан баг амжилттай ажилласан. Үндэсний Хөгжлийн Хүрээлэн гол ажлыг хийсэн. Та бүхнийг очиход энэ

тухай дэлгэрэнгүй ярих байх.

Манай ШУА нь ШУА-ийн статусын хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг. Энэ хуулийн дагуу ШУА нь Монгол улсын шинжлэх ухааны төв байгууллага бөгөөд Монгол улсын хөгжлийн бодлогыг төр засагтай зөвлөх үүрэгтэй байгууллага. Манай ШУА төрийн төлөөлөл орсон, эрдэмтдийн сонгуулиар гарсан, засгаас санхүүждэг байгууллага. Үүгээрээ БНХАУ, ОХУ-ын шинжлэх ухааны академиас арай онцлогтой. Манай ШУА-ийн Ерөнхийлөгчийг МУ-ийн Ерөнхий сайд батламжилдаг. ШУА-ийн Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын ШУ салбарын бодлогын зөвлөхийн статустай. ШУА-ийн эрхзүйн баримт бичгүүд үндсэндээ бүрдсэн. Шинжлэх ухаан, технологийн хууль гэж байдаг. Монголын парламентаас баталсан “Шинжлэх ухаан, технологийн төрөөс баримтлах бодлого” гэж баримт бичиг байдаг.

Засгийн газраас баталсан “Монгол улсын шинжлэх ухаан, технологийн 2020 он хүртэл хөгжүүлэх мастер хөтөлбөр” бий. “Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр” гэж бий. (2016 оноос хэрэгжүүлэх). УИХ-аар инновацийн хууль дөнгөж саяхан батлагдсан. Энэ хуулиар мэдлэгийг бий болгох, мэдлэгийг технологижуулах, технологийг практикт нэвтрүүлэх бололцоо бүрдэнэ.

ШУА нь 800 орчим эрдэм шинжилгээний ажилчидтай. Нийт ажиллагсад 1100. 22 хүрээлэнтэй. ШУА-д Монголын орон тооны эрдэм шинжилгээний ажилчдын 70% харьяалагддаг. Манай академи нийгмийн болон байгалийн шинжлэх ухааныг бүхэлд нь хамардаг. Бүтэц зохион байгуулалтын тухайд, Монголын эрдэмтдийн төв байгууллагын хувьд эрдэмтдийн төлөөллийг багтаасан бага чуулган гэж байдаг. Таван бага чуулгантай. Нийтдээ 111 гишүүнтэй. Бага чуулганаараа шинжлэх ухааны бодлогын асуудлыг хэлэлцдэг.

ШУА-ийн хуулийн дагуу хоёр салбарын академи байдаг. /байгалийн шинжлэх ухааны болон нийгмийн шинжлэх ухааны/. Монголд эрдэм шинжилгээний ажлын 20-иод хувь нь их сургуулийн дэргэд хийгддэг. 20-иод хувь нь хувийн секторт хийгддэг. Академийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулдаг Тэргүүлэгчдийн газар гэж байдаг.

Манай судалгааны чиглэл их өргөн, тухайлбал: Геологи, уул

уурхай, Ботаник, ургамал, Биотехнологи, Хими, хими технологи гэх мэт.

Танай академитай хамтын ажиллагаа хөгжүүлэх боломжтой 10-аад хүрээлэн бий. Түүх, Олон улс судлал, Хөгжлийн бодлого, Эрх зүй, улс төр судлал, Хэл зохиолын гэх мэт.

Манай улс ДНБ-ын 0,2%-ийг шинжлэх ухаанд зарцуулж байгаа. Ойролцоогоор 16 тэрбум төгрөг байдаг. Хуулиараа бол 1,5%-аас доошгүй. Энэ нь манай өмнөд хөрштэй харьцуулахад маш бага. Санхүүгийн хүндрэлтэй нөхцөлд ажиллаж байна. Эдийн засгийн өсөлт сайн байгаа учраас хэмжээ нь абсолютаар өсч байгаа.

Айлчлалын хүрээнд та бүхэн манай хэд хэдэн хүрээлэнтэй танилцана. Миний бодлоор манай хоёр байгууллагын хүрээнд судалгааны олон сайхан чиглэл байх боломжтой гэж үзэж байгаа. Түүх, этнографийн судалгаанаас эхлээд зүүн ази, зүүн хойд ази, бүс нутгийн асуудлыг хамарсан судалгаа байж болно. Манай байгууллагуудын хооронд энэхүү гэрээнд гарын үсэг зурсанаар хамтын ажиллагааны чиглэлүүд тодорхой болж, харилцан эрдэмтэд солилцож, хамтарсан хурал зөвлөгөөнүүд зохион байгуулж, хамтарсан бүтээл гаргах өргөн боломж нээгдэнэ гэж бодож байна.

Манай байгууллага нь Ази, Европ, Африк, Америкийн төлөөлөл орсон 30-аад оронтой харьцдаг. 100 гаруй төсөл хэрэгждэг. Одооноос эхлээд танай байгууллагатай хамтран ажиллах үүд нээгдэж байна.”

БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн Ерөнхийлөгч Нгуен Суан Тханг Монголын ШУА-ийн Ерөнхийлөгч, удирдлагууд халуун дотноор угтаж авсанд баярлаж байгаагаа илэрхийлээд, өөрийн байгууллагын болон Вьетнам орны талаар танилцуулж хэлэхдээ:

“Бидний хувьд анх удаа манай Нийгмийн ШУА-ийн төлөөлөгчид танай оронд айлчилж, энэ үеэрээ хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурах гэж байгаадаа сэтгэл хангалуун байна. Монгол, Вьетнам 2 улс уламжлалт найрсаг харилцаатай. Энэхүү айлчлалын үр дүнд бидний хамтын ажиллагааны нэг шинэ үе эхэлж байна гэж хэлж болно. Манай хоёр орны шинжлэх ухааны салбарын харилцаа хөгжих жинхэнэ цаг нь болсон гэж үзэж байна. Яагаад гэвэл бид хэн хэн нь эдийн засгийн хөгжилдөө түлхүү анхаарч байсан

бол одоо шинжлэх ухааны хөгжил рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлага урган гарч ирж байна. Эрхэм Ерөнхийлөгч таны хэлсэнчлэн өнөөдөр гарын үсэг зурах гэрээ нь энэ ажлын эхлэлийг тавьж үүдийг нээж өгч байгаатай санал нэгтэй байна.

Манай зочдын бүрэлдэхүүнд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч хамт багтсан нь бид энэхүү айлчлалд их ач холбогдол өгч байгаагийн нэг илрэл гэж хэлж болно. Түүнээс гадна Гадаад харилцааны хэлтсийн дарга, Европ садлалын хүрээлэнгийн захирал, Төвийн бүсийн тогтвортой хөгжлийн хүрээлэнгийн захирал, Хятад судлалын хүрээлэнгийн дэд захирал, Санхүүгийн хэлтсийн дэд захирал айлчилж байна.

Манай улсад шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаа Нийгмийн ШУА, Байгалийн ШУА гэсэн 2 байгууллагад хуваан явуулдаг. Хоёр академийн ерөнхийлөгч хоёулаа ВКН-ын Төв хорооны гишүүн байдаг. Улс төрийн товчоо томилж, Ерөнхий сайд батламжилдаг. Академийн ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын зөвлөхийн албыг давхар гүйцэтгэдэг.

Манай байгууллага үндсэн 3 үүрэгтэй.

- Шинжлэх ухааны суурь судалгааг хийж, онол, бодлого, хөгжлийн асуудлыг судлах,
- Судалгааны мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх,
- Яам тусгай газрууд, орон нутгийн удирдлагуудад шинжлэх ухааны бодлогын асуудлаар зөвлөх,

Одоогоор манай байгууллага 2000 гаруй ажилтантай. 800 гаруй нь эрдмийн зэрэг цолтой. Боловсон хүчнээ дотооддоо болон гадаадын олон оронд бэлтгэдэг.

Судалгааны 4 үндсэн салбартай.

- Нийгмийн ШУ-ны салбар : философи, эрх зүй, эдийн засгийн гэх мэт хүрээлэнгүүд,
- Соёл хүмүүнлэгийн ШУ-ны салбар: Соёл, хэл, утга зохиолын гэх мэт хүрээлэнгүүд,
- Олон улс судлалын ШУ-ны салбар, энэ салбар нь олон улсын эдийн засаг, улс төрийн чиглэлийн судалгаа хийдэг Европ судлалын, Америк судлалын, Хятад судлалын, ЗХА судлалын гэх мэт хүрээлэнгүүдтэй,

- Дотоодын бүс нутаг судлалын салбар: манай улс газарзүйн хувьд өвөрмөц тогтоштой, байгаль цаг уурын хувьд өөр өөр учраас бүс нутаг болгон өөр өөрийн онцлогтой, үүнийг тусгайлан судлах шаардлагатай байдаг.

Манай байгууллага 32 хүрээлэн, хэд хэдэн судалгааны төвүүдтэй. 30 гаруй судалгааны сэтгүүлтэй. 2 хэвлэлийн үйлдвэртэй. Олон үндэстэнтэй улс учраас тэдгээрийн судалгааны үр дүнг нийтэд таниулах зорилготой Угсаатны зүйн музей бас манайд харъяалагддаг. Нийгмийн шинжлэх ухааны чиглэлийн 44 мэргэжлээр судлаач боловсон хүчин бэлтгэдэг дээд сургуультай. Бид 100 гаруй оронтой харилцдаг. Хамтын ажиллагаа бүх хэлбэрээр явагддаг. Бусад орнуудтай харилцаж байгаагийн зарим нь байнгын үйл ажиллагаатай, зарим нь эрдэмтэд, материал солилцох хэлбэрээр явагддаг.

Яг одоогийн шатанд бид үндсэн хуулиа шинэчлэх үйл явцад манай байгууллагын эрдэмтэд оролцож байна. Үндсэн хуулиа шинэчлэх нь маш чухал ажил учраас энд эрдэмтэд, судлаачдын оролцоо чухал үүрэгтэй. Өөрчлөлт шинэчлэлтийн 20 жилийн дүнд бид зах зээлийн эдийн засагтай болсон. Нийгмийн эрх зүйн тал дээр амжилт олсон. Ардчилсан нийгмийг төлөвшүүлж эхэллээ. Энэ 3 зүйлийг цаашид хэрхэн хөгжүүлэх вэ гэдэг асуудал тулгараад байгаа энэ чухал үед үндсэн хуулиа шинэчлэх ажил хийгдэж байна. ВКН-ын 11-р их хурлаас хойш 1 жил гаруй хугацаа өнгөрлөө. Эдийн засгаа түргэн хөгжүүлэх, энэ хөгжлөө тогтвортой хадгалах гэсэн 2 зорилт манай улсын өмнө тулгараад байна. Энэ 2 зорилтоо хангахад бодлогын чанартай чухал баримт бичиг байх ёстой. Ийм учраас шинжлэх ухааны байгууллагууд улс орны энэ зорилтыг хэрэгжүүлэхэд амьдралд ойрхон, бодитой баримт бичигтэй болоход өөрийн хувь нэмрийг оруулах ёстой. Эдийн засгийн хөгжлийг бодитой болгох ёстой. Байгалийн баялгийг бүрэн дүүрэн ашиглахын тулд чадварлаг боловсон хүчин бэлтгэх асуудалд бид их анхаарч байгаа. Нийгмийн асуудлыг нэлээн гүнзгийрүүлж судлах шаардлагатай байна. Ажилгүйдлийг багасгах, нийгмийн тэгш биш байдлыг арилгах, нийгмийн бусад асуудлыг зохицуулахын төлөө ажиллаж байна. Энэ ажилд манай байгууллага бас өөрийн хувь нэмрийг оруулах ёстой.

Манай улс сунаж тогтсон нутаг дэвсгэртэй. Ийм учраас бүс нутгийн хөгжилд ихээхэн анхаардаг. Тухай бүрт нь тохирсон хөгжлийн бодлого байх шаардлагатай. Соёлын өв, түүнийг хадгалж үлдэх, аялал жуулчлалд хэрхэн ашиглах вэ гэх мэт олон асуудлыг судалдаг. Олон үндэстэн ястантай учраас соёлын баян өв уламжлалтай. Архелогийн хувьд судлах ажил маш их байдаг. Эртний түүхтэй улс орон учраас.

Түүнээс гадна орчин үеийн даяаршиж байгаа энэ үед эдийн засгаа хэрхэн үүнтэй зохицуулах вэ гэдэгт их анхаарч байна. Олон улс судлалын ажил ихээхэн анхаарал татсан судалгаа байдаг. Их гүрнүүдийн бодлого, түргэн хөгжиж байгаа улсуудын тухай судлах шаардлагатай. Энэ нь зөвхөн эдийн засгийн асуудал биш, улс төр, аюулгүй байдал, тайван тогтвортой хөгжихөд энэ асуудал чухал учраас нарийн судлах шаардлагатай. Бүс нутгийн хувьд өмнөд тэнгисийн асуудал, хилийн асуудал их чухал гэх мэт олон чиглэлийн судалгаа бид хийдэг. Тийм учраас манай 2 байгууллага маш өргөн хүрээнд хамтарч ажиллах боломжтой гэж үзэж болно. Жишээлбэл: дэлхийн эдийн засгийн өнөөгийн байдалд яаж зохицож улс орноо хөгжүүлэх вэ гэдэг нь бидний нийтлэг асуудал. Үүнийг хамтарч судалж болно. Вьетнамын эдийн засгийн давуу тал юу байна, Монголын давуу тал юу байна гэдгийг судалж, харилцан туршлага солилцож болох юм. Харилцан бие биенээ нөхөх боломж байна уу гэдгийг хамтдаа олж харах нь их чухал. Манай улс байгалийн баялаг ихтэй. Танай улс мөн адил. Нүүрс, газрын тосны олборлолт ашиглалтын тал дээр бид арвин туршлагатай, та бүхэнтэй хуваалцахад бэлэн байна. Ажиллах хүчний асуудал дээр хамтран ажиллаж болно. Манай улс бараг 90 сая хүн амтай. Хөгжил, бодлогын асуудал дээр хамтрах зүйл их байна гэж харж байна. Том гүрнүүдийн дэргэд байгаа жижиг улсуудын хувьд нийтлэг асуудлууд ихтэй. Хамгийн гол зүйл нь хилийн аюулгүй байдал, том гүрний нөлөө, дарамтаас өөрийгөө хэрхэн хамгаалах вэ, учирч болох бэрхшээлийг хэрхэн даван туулах вэ гэдэг асуудал чухал. Сөргөлдөх биш, хэрхэн хамгаалах, даван туулах вэ гэдэг их чухал. Энэ тал дээр бид бас тодорхой туршлага хуримтлуулж чадсан. Энэ асуудлаар гадны улсуудыг урьж хамтарсан хурал зохион байгуулах боломж бий. Жишээлбэл: АНУ-Мексик,

АНУ-Канад, Монгол-ОХУ, Монгол-БНХАУ, Вьетнам-Лаос, Вьетнам-Камбож гэх мэт. АНУ-Канадын хувьд бас тодорхой асуудлууд байдаг. Канадын ард түмэн “Америктай хэт ойртох ч хэрэггүй, хэт холдох ч хэрэггүй” гэсэн зарчим баримталдаг. Үүнийг их зөв гэж үзэж байна.

Түүх архелогийн салбарт бид хамтран ажиллах бүрэн боломжтой. Хэрвээ та бүхэнд манай эртний түүхтэй холбоотой баримт материал байдаг бол бидэнд их хэрэгтэй.

Өнөөдөр бид хамтын ажиллагааны ерөнхий асуудлуудыг ярилцлаа. Үүнийхээ эхлэл болгож гэрээнд гарын үсэг зурах гэж байна. Эхний ээлжинд эрдэмтэд солилцох, харилцан туршлага судлах, ном сэтгүүл, эрдэм шинжилгээний бүтээл солилцох боломжтой. Дараа нь хамтарсан төсөл хэрэгжүүлж болно. Хамгийн эхний ээлжинд хийх боломжтой ажил бол судлаач солилцох. Өнөөдөр зурагдах гэрээний дагуу явуулж байгаа тал замын зардлаа хариуцаж, хүлээн авч байгаа тал хоол байрны асуудал, ажиллах нөхцөл бололцоог хангаж өгөх юм. Энэ оны 11 сарын 26-28 нд Ханой хотноо Вьетнам судлалын олон улсын 4-р хурал болно. Бидний олж мэдсэнээр танай байгууллагад Вьетнамын талаар судалгаа хийдэг эрдэмтэд байдаг юм байна. Хэрвээ боломжтой бол тэр хурлын үеэр Монголын ШУА-ийн Ерөнхийлөгчийг манай оронд айлчилж энэ хуралд оролцохыг урьж байна. 800 орчим төлөөлөгч оролцоно гэсэн төлөвлөгөөтэй байгаа. 400 орчим нь гадаадын төлөөлөгчид. Үүний дотор Монголын төлөөлөгчид байна гэдэгт итгэж байна. Бидний хамтын ажиллагаа эхэлж байгаа энэ үед та бүхнийг оролцоно гэж найдаж байна. Хэрвээ эрхэм ерөнхийлөгч та манай энэ хуралд оролцвол богино хугацаанд Вьетнамын талаар маш их мэдээлэл олж авах боломжтой. Мөн энэ үеэр бид хамтын ажиллагааны талаар илүү дэлгэрэнгүй ярилцах боломжтой.

Та бүхэнд биднийг хүлээн авч уулзан, үйл ажиллагааныхаа талаар ярьж өгсөнд баярлаж байгаагаа дахин илэрхийлээ” гэлээ.

Үүний хариуд ноён Б.Энхтүвшин: “Тантай санал нэг байна. Хоёр байгууллагын харилцааг эрчимтэй хөгжүүлцгээе. Тэр хуралд бид эрдэмтдээ оролцуулья. Манай хоёр байгууллагын хувьд адил төстэй зүйлүүд бас их байдаг юм байна. Та бүхэн УИХ-ын Нийгмийн

бодлогын байнгын хорооны даргатай уулзахдаа өөрийн байгууллагын хийж байгаа судалгааны ажлаас, тухайлбал эдийн засгийн хөгжлийн судалгаа, хилийн асуудлын талаар туршлагаас илүү дэлгэрэнгүй ярьж өгөөрэй. Тэр “хэт ойртох хэрэггүй, хэт холдох хэрэггүй” гэдгээ заавал хэлээрэй. Яагаад гэвэл заримдаа манай улс хэн нэгэнтэй нь хэт ойртох гээд байдаг талтай. Мөн бидэнтэй залгаж буй хөршүүд хоорондоо ойртох нь их аюултай гэж манай судлаачид үздэг.

Таны ярьсан зүйлээс зарим нэгийг нь тодруулахыг хүсч байна.

- Танай байгууллага дэргэдээ судлаач бэлтгэдэг сургуультай юм байна. Вьетнамд нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр их сургуулиуд дээр хийгдэж байгаа судалгаа танай байгууллага дээр хийгдэж байгаа судалгаа хоорондоо яаж уялддаг вэ?

- Манай ШУА-ийн эрдэмтдийн дундаж нас 38. 35 хүртэлх насны залуучууд 48% байна. Тийм учраас манай академийн хэмжээнд залуу судлаачдыг дэмжих, сургах, эрдэм мэдлэг, мэргэжлийг нь дээшлүүлэхэд анхаарч байна. Залгамж халаагаа бэлтгэх асуудал бидний хувьд хүндрэлтэй. Нэг нь дөнгөж судалгааны ажилд суралцаж эхэлж байхад нөгөө нь тэтгэвэртээ гарч байна. Танайд энэ асуудал байдаг уу?

- ШУ-ны санхүүжилт ямар түвшинд байдаг вэ?” гэсэн асуултууд тавив.

БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн Ерөнхийлөгч хариулахдаа:

- Судалгааны ажил 3 түвшинд явагддаг. Эрдэм шинжилгээний байгууллагуудын 1 хэсэг нь академийн харъяанд, 1 хэсэг нь яам тамгын газруудын дэргэд, 3 дахь хэсэг нь их дээд сургуулиудын дэргэд үйл ажиллагаагаа явуулдаг. Академийн судалгаа суурь судалгаа байдаг. Улсын хэмжээний том, бодлогын чанартай асуудлуудыг судалдаг. Яам тамгын газруудын судалгааны байгууллага нь хавсарга судалгаа, өөрийн байгууллагын хүрээнд судалгааг хийдэг. Их дээд сургуулиудын дэргэдэх судалгааны байгууллага нь сургалтын арга барилын талаар голлон судалдаг. Академи нь Төрийн бодлоготой холбоотой, эсвэл стратегийн чиглэлийн судалгааг, мөн Улс төрийн товчоо, Засгийн газрын захиалгын судалгааг хийдэг. Мөн хамтарсан эрдэм шинжилгээний хурлууд зохион байгуулдаг. Академи зөвхөн дотоодын байгууллагуудыг хамарсан хурал хийхээс гадна гадаадын

судлаачдыг урьж хурал зохион байгуулдаг. Манайд орон нутагт судалгааны төвүүд бас байдаг. Эдгээр төвүүдэд академи бас тусалдаг.

- Улсын төсвийн 2 % нь ШУ-ны салбарт ногддог. Гэхдээ салбаруудад ногдох хэмжээ харилцан адилгүй. Манайд бас төсөв хүрэлцдэггүй. Тийм учраас төсвөөс гадуур орлого олоход их анхаардаг. Олон улсын байгууллагын тусламжийг хамтарсан төсөл хэрэгжүүлэх хэлбэрээр авдаг. Тендерт бас оролцдог. Саяхан “Үндэсний хөгжлийн сан” гэж байгуулагдсан. Эндээс ШУ-нд бас онолын судалгаанд тодорхой хэмжээгээр тусалдаг.

- Залгамж халааны асуудал бидэнд ч бас байдаг. Бид боловсон хүчнээ дотоод, гадаадад бэлтгэдэг. Хувийн шугамаар болон Засгийн газрын шугамаар явуулж бэлтгэдэг. Хамгийн гол нь судалгааны ажлаар дамжуулж сургаж авахад их анхаардаг. Хамтарсан төсөл, судалгаанд залуучуудыг татан оролцуулж сургадаг. Түүнээс гадна ахмад эрдэмтдийг дагалдуулж залуучуудаа бэлтгэдэг. Судалгааны ажилд сонирхолтой, чадварлаг залуучуудыг сайн дэмжих хэрэгтэй. Зоригтойгоор ажил даалгах хэрэгтэй гэсэн зарчим баримталдаг. Манайд бас залуучууд олон бий. Хүрээлэнгийн захирлаар 36 настай залуу ажиллаж байгаа тохиолдол бий. Ахмад судлаачдаа урьж хамтарч ажиллах явдал бий. Судалгааны ажилд нас хамаарахгүй гэж үздэг учраас.

Ийнхүү санал бодлоо чөлөөтэй солилцсоны дараа хамтарч ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа. Хоёр академи хооронд шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурахад манай талаас ШУА-ийн ерөнхийлөгч Б.Энхтүвшин, дэд ерөнхийлөгч Т.Дорж, Гадаад харилцааны хэлтсийн дарга Л.Даваагив, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал Л.Хайсандай, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирал Б.Цогоо, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Шүрхүү, Вьетнамын талаас хүндэт зочдоос гадна БНСВУ-аас манай улсад суугаа Элчин сайд Хоанг Туан Тхинь нар байлцлаа.

Дараа нь төлөөлөгчид Үндэсний хөгжлийн хүрээлэнд зочлов. Тус хүрээлэнгийн захирал Б.Цогоо зочлод өөрийн байгууллагын үйл ажиллагааны талаар товч танилцуулан, Вьетнамын талын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран ажиллах

хүсэлтэй байгаагаа илэрхийлэв.

Айлчлалын дараагийн өдөр төлөөлөгчид Олон Улс Судлалын хүрээлэнд зочлов. Уулзалтанд ОУСХ-ийн ЭНБД Д.Шүрхүү, эрдэмтэн Ц.Баатар, Л.Бэгзжав, А.Буянтөгс, Д.Золбоо, Ч.Батцэцэг, М.Хурметхан, Ц.Дашцэвэл, А.Нямдолжин, Б.Цэнгэлхам нар байцлаа.

Захирал Л.Хайсандай зочдыг хүлээн авч, өөрийн хүрээлэнд хүрэлцэн ирсэнд талархалаа илэрхийлээд, байгууллагынхаа үйл ажиллагааны тухай товч танилцуулав.

Тэрээр хэлэхдээ "Манай хүрээлэн 40 гаруй хүнтэй. 38 нь ЭША. Үүнээс 4 шинжлэх ухааны доктор, 12 доктор, 13 магистр, 3 докторант. 78% нь эрдмийн зэрэг цолтой. Үйл ажиллагааны хувьд Хятад судлал, Орос судлал, Америк судлал, Япон судлал, Европ судлал, Зүүн Өмнөд Ази судлал гэсэн 6 сектортой. Эрдэм шинжилгээ, судалгааны 6, 7 төрлийн сэтгүүл гаргадаг.

Манай хүрээлэнгийн нэг онцлог нь Монгол улсын хэмжээнд Вьетнам судлал явуулдаг цорын ганц байгууллага. Манай хүрээлэн байгуулагдаад 44 жил болж байна. Анх байгуулагдахад л ЗӨА судлал, Вьетнам судлалын салбар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Энэ чиглэлээр нилээн хэдэн бүтээл гаргасан.

Манай хүрээлэн өнгөрсөн 5 жилийн хугацаанд 24 ном хэвлүүлсэн. 10-аад орны 20 орчим байгууллагатай хамтын ажиллагаатай. Бусад орнуудтай судлаач солилцдог. Засгийн газар, яамдуудад зөвлөмж гаргаж өгдөг. Гол чиглэл нь 2 хөршийн судалгаа.

ОУ-ын хурлууд тогтмол зохион байгуулдаг (Орос, Япон, Америк, Хятад, Солонгостой хамтарч). Та бүхэн манай байгууллагад айлчилсанаар манай хүрээлэнгийн Вьетнам судлал эрчимтэй хөгжинө гэж итгэж байна.

Бидний зүгээс танай талд тавих хэд хэдэн санал байна.

1. Вьетнам судлалын эрдэмтдийг хүлээн авч судалгаа хийхэд дэмжлэг үзүүлнэ байх гэж найдаж байна.
2. АСЕАН судлалыг их сонирхож байна. Манай улс АСЕАН-нд ямар нэг статустай болох зорилт тавьж байна.
3. Хятад судлалаар хамтарч ажиллах хүсэлтэй байна.

Орос, Америк, Европ, ЗХА судлалаар мөн хамтарч ажиллах хүсэлтэй байна.” гэлээ.

БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн Еөрнхийлөгч Нгуен Суан Тханг хэлэхдээ: Мэргэжил нэгт нөхөдтэйгөө уулзаж байгаадаа баяртай байна. Таны танилцуулсанаас үзэхэд танай байгууллага цөөн ажилтантай ч гэсэн судалгааны хамрах хүрээ маш өргөнтэй юм байна. Орчин үеийн тулгамдсан асуудлыг судалдаг нь сонирхол татлаа. Академи хооронд хамтын ажиллагаа хөгжүүлэх гэрээ байгуулах санаачлага танай хүрээлэнгээс гарсан гэдгийг сонсоод маш их баяртай байна. Энэ нь угтаа та бүхэн манай орныг хэр их анхаарч, сонирхдог гэдгийн илрэл юм. Бидний айлчлалын бүрэлдэхүүнд байгаа хүмүүсийн дийлэнх нь олон улс судлалын чиглэлийн мэргэжилтэнгүүд.

Олон улс судлалаар бид хамтран ажиллах хэд хэдэн асуудал байна байна. Үүнд:

1. Хамгийн түрүүнд бид Хятадын талаар хамтарч судлах ёстой. Хятадын эдийн засаг эрчимтэй хөгжиж байна. Хятад бүс нутгийн чухал гүрэн болсон. Удахгүй 18-р хурал нь болно. Өөрийн орны эдийн засгийн хөгжлийн талаар анхаарч байна. Дэлхийн бусад том гүрнүүдтэй хэрхэн харьцах вэ гэдэг асуудлыг хөндөх гэж байна. Хятадын хөгжил мэдлэгт суурилсан орчин үеийн технологийг нэвтрүүлэх замаар эдийн засгаа хөгжүүлж, дэлхийн том их гүрэн болох бодлого барьж байна. Хятадтай харьцах асуудал бүх улсын хувьд их чухал болж байна. Бидний хувьд хоёулаа хөрш орон учраас сайн муу аль аль талыг нь хамтарч судлах шаардлагатай байна.

- Эргэн тойрны орнууддаа эдийн засгийн нөлөөгөө бэхжүүлэх ажил Хятад их явуулж байна.

- Манай хоёр орны хувьд зах зээл нь бараг л Хятадын мэдэлд ороод байсан. Эргэн тойрны жижиг орнуудын зах зээл рүү бараагаа их хэмжээгээр шахаж, уул уурхай руу их анхаарч байгаа нь бидний байгаль орчинд сөргөөр нөлөөлж байна.

- Хилийн маргаан, аюулгүй байдлын хувьд бас анхаарах хэрэгтэй.

- Хил залгаа орны ховор бүхнийг өөртөө татах бодлого

явуулж байна.

- Хууль бус наймаа, хүний наймаа гэх мэт зүйл их бий.

Гэхдээ мэдээж бид Хятадтай хамтарч ажиллах ёстой. Том зах зээлийг ашиглах хэрэгтэй. Судалгааны ажил үргэлж сайн муу хоёр талыг тусгах ёстой. Тэнцвэртэй байдалд тулгуурлах. Бидний хувьд адил нөхцөлд оршдог, асуудал нэгтэйн хувьд өөрсдийн хэмжээнд харилцан бодлоо солилцож, хамтарч ажиллах шаардлага маш их байна.

2. ЗХА. Та бүхнийг ЗХА, тэр дундаа Япон, Солонгосын асуудлыг их анхааран, ашиг сонирхлын тэнцвэрийг олж харьцаж байгаад их талархалтай байна. Бид ч бас энэ талаар их анхаардаг. Одоогоор Япон хөрш орнуудаасаа нэгт явж байгаа. Солонгос мөн эдийн засгийн чадавхи өндөртэй улс. Япон-Вьетнам, Солонгос-Вьетнамын хооронд стратегийн түншлэлийн харилцаатай. Иймэрхүү асуудлууд бас л бидний хооронд санал бодлоо солилцох нэг сэдэв.

3. АСЕАН нь олон жилийн түүхтэй хамтын ажиллагааны үйл явц. Та бүхэн мэдэж

байгаа байх, АСЕАН одоогоор богино хугацаанд эдийн засгийн хамтын ажиллагаа илүү хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж, 2015 он гэхэд харьцангуй чөлөөтэй, нээлттэй эдийн засаг бүхий том зах зээл болох зарчим тавин ажиллаж байна. АСЕАН +3 механизм хөгжиж байгаа ч гэсэн олон орон АСЕАН +1-ийг илүү үзэж байна. Жишээ нь: Хятад бол Хятад+АСЕАН гэсэн механизм байх ёстой гэж үздэг, тэрнээс биш АСЕАН+Хятад биш.

Маш тодорхой нэг зүйл бол Япон, Хятад, Солонгост АСЕАН маш их хэрэгтэй. Олон улсын эрдэмтдийн үзэж байгаагаар: АСЕАН нь ЗХА-тай АСЕАН -ны гишүүн орнуудыг холбох гүүр нь болж өгдөг.

Энэ бүс нутаг дахь АФТА буюу АСЕАН-ны Чөлөөт худалдааны бүсийн гол үндэс нь АСЕАН. Ийм учраас та бүхэн АСЕАН-ыг сонгон судалж байгаа нь маш зөв гэж би үзэж байна. АСЕАН дотор Вьетнамын үүрэг их чухал гэдгийг би цохон тэмдэглэмээр байна. Өмнө нь бусад орнууд Вьетнамыг Лаос, Камбожийн адил гэж үздэг байсан. Өөрөөр хэлбэл АСЕАН дахь хөгжил дорой нэгэн орны нэг гэж үздэг байсан. Одоо энэ үзэл их хоцрогдсон. Энэ нь

дараахь гурван шалтгаантай. Үүнд:

- Одоо Вьетнамын эдийн засгийн хөгжил дорой орноос дундаж хөгжилтэй оронд шилжсэн.
- Улс төрийн тогтвортой байдалтай, ДХБ болон олон улсын байгууллагад элсэн орсон. АСЕАН-ны бодлогыг тодорхойлогч гол орон болсон, тэрнээс биш хөгжлөөрөө тэргүүлэгч орныг дагалдагч орон биш.
- Меконгийн бүс нутаг дотроо Энэтхэг, Хятадын хойгийн орнуудыг Хятадтай холбогч гол гүүр нь Вьетнам гэж хардаг болсон.

Үүнээс илүүтэйгээр олон орнууд Вьетнамтай хамтын ажиллагаа хөгжүүлэхийг хичээдэг болсон. ЗӨА дахь хүчний тэнцвэрийг бий болгоход Вьетнам чухал гэж үздэг.

Ийм учраас миний хэлсэн гурван асуудлаар, Хятад, Зүүн Хойд Ази, АСЕАН-ыг Вьетнамтай холбож судалгаа хийж байгаа нь их чухал гэж үзэж байна. Бусад судалгаанд хэрэгтэй.

Тийм учраас хамтын ажиллагааны хэлбэр, агуулгаа төлөвлөж, хөтөлбөр гаргаж айлчлах хэрэгтэй. Манай академид танайхтай холбогдох боломжтой олон хүрээлэн бий. Хятад, ЗХА, ЗӨА, Дэлхийн улс төр, эдийн засгийн хүрээлэн гэх мэт.

Иймд Вьетнамд очиж яг ямар асуудалтай танилцмаар байгаа, хаана очмоор байгаа гэдгээ гаргавал бид нөхцөл бололцоогоо дайчлан туслах болно.

Академи хооронд байгуулсан гэрээг үндэс суурь болгон хамтын ажиллагааны хөтөлбөр боловсруулах (суурь судалгааны чиглэлээ тодорхойлох). Өмнө бий болсон хоёр орны эрдэмтэн судлаачдын хамтын ажиллагааг цааш нь хөгжүүлэх, хамтын бүтээлүүд гаргах байх гэж найдаж байна.

Өмнө хэлсэнчлэн Монголын эрдэмтэн судлаачид Хятадын асуудлыг юу гэж харж байгаа гэдэг бидний хувьд их сонирхолтой. Монголын хөгжлийн бодлого ямар байна? Бүс нутагт эзлэх байр суурийг бид бас мэдмээр байна. Вьетнам, Монголын эдийн засгийн харилцааг яаж нэмэгдүүлж, худалдааны эргэлтийг сайжруулах вэ гэдгийг судлах нь манай хоёр орны эрдэмтэдийн хийх ажил. Монголд олон

төрлийн бараа бүтээгдэхүүн Вьетнам руу экспортлох боломжтой. 90 сая хүнтэй том зах зээл шүү. Цагаан будаагаар Вьетнам их сайн болж байгаа. Олон нэр төрлийн бараа нийлүүлэх боломжтой. Танай оронд ч гэсэн манай орон руу экспортлох боломжтой бараа бүтээгдэхүүн их бий нь тодорхой.

Хэрвээ та бүхэн боломжтой бол энэ оны 11 сард зохиогдох Вьетнам судлалын их хуралд оролцвол Вьетнамын талаар маш олон зүйлийг сонсож мэдэх болно гэж бодож байна. Энэ хуралд зөвхөн Вьетнамын судлаачид биш, гадны олон орны эрдэмтэд оролцох учраас маш сонирхолтой байх болно.

Өчигдөр академийн ерөнхийлөгч Б. Энхтүвшин дарга энэ хуралд оролцоно гэдгээ хэлсэн. Товчлон хэлбэл ирээдүйд хамтран ажиллах эхлэлийг тавьсандаа маш их баяртай байна.” гэлээ.

Хоёр академийн харилцааг хөгжүүлэхэд манай улсын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, БНСВУ-ын Нийгмийн ШУА-ийн Зүүн хойд ази судлалын хүрээлэнгийн үр бүтээлтэй хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэх гүүр нь болох ихээхэн боломж нөөц байна гэж талууд үзэн, дараагийн удаа энэхүү хоёр хүрээлэнгийн хооронд хамтын ажиллагааны гэрээ байгуулахаар тохиролцлоо.

Үүний дараа төлөөлөгчдийг Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн захирал, академич Ж.Амарсанаа хүлээн авч өөрийн байгууллагын талаар товч танилцуулан, харилцан санал солилцлоо.